



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ДҮГНЭЛТ: УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ОРУУЛСАН ЗАРИМ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

Аудитын сэдэв: “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

Аудитын код: БХА-2026/05-03/ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Цахим хуудас: doljmaab@audit.gov.mn

Аудитор Д.Цэдэвцэвээн

Цахим хуудас: tsedevtseveend@audit.gov.mn

Аудитор Д.Даваадорж

Цахим хуудас: davaadorjd@audit.gov.mn

Баянхонгор хот. 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 4/11

Номгон

Г Гүйцэтгэлийн аудитын тайлан Г
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны А/175 дугаар тушаалаар баталсан "Эрх шилжүүлэх" тухай тушаалын 3 дугаар хавсралтын 1 дэх заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" (БХА-2026/05-03/ШТА-НА кодтой) сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл аудитын газар, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Н.Батсуурь, аймгийн Засаг дарга Э.Энхбат, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэг, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Должмаа)-д даалгасугай.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга (Э.Энхбат), аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Б.Должмаа), аудитор (Д.Даваадорж) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Алтантуяа)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

Дарга, Тэргүүлэх аудиторын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний
өдрийн А/11 дүгээр тушаалын хавсралт

**"Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн аудитаар өгсөн
зөвлөмж, албан шаардлагын жагсаалт**

№	Шалгагдагч байгууллагын нэр	Товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Гаргасан шийдэл
1	2	3	4	5
1	Аймгийн Засаг дарга	Заг сумын сургуулийн барилгыг 2025.11.18-ны өдөр улсын комисс хүлээн авсан, барилгыг ашиглаж эхлээгүй байхад аймгийн Засаг даргын 2026.02.09-ний өдрийн А/89 дүгээр захирамжаар 224.7 сая төгрөгийн чанарын баталгааг олгосон байна.	224,757.0	Албан шаардлага өгөх
2	Аймгийн Засаг дарга	Заг сумын сургууль, Галуут сумын төвийн шинэчлэл зэрэг төсөл арга хэмжээг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хянаагүй байхад барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлтийг гаргаж, гүйцэтгэлийн санхүүжилтийг олгосон байна.	990,943.9	Албан шаардлага өгөх
3	БОНХОБТХ	Баянбулаг сумын дотуур байрны барилгын ажлын дулааны шугмын ажлыг зураг төсөвт байсан хэмжээнээс бага зайд гүйцэтгэж, хэмнэгдсэн төсвөөр зураг төсөвт тусгаагүй ажлыг хийсэн гэх боловч хурлын тэмдэглэлээр баталгаажуулаагүй, хийсэн ажлын тайланг тоо хэмжээ, мөнгөн дүнгээр баталгаажуулаагүй байна.	-	Албан шаардлага өгөх
4	ГХБХБГ	"Цэвэр хот" ОНӨӨӨТҮГ-ын ажилчдын байр, халуун усны барилгын ажил гүйцэтгэгч "Джихангар" ХХК нь барилгын гадна тохижилтын ажил 70 хувийн гүйцэтгэж бүрэн дуусаагүй, барилгын гаднах хаяавчны цутгалт бүрэн хийгдээгүй, цутгасан бетон хөлдөж хагарсан байдалтай, комиссын гишүүдээс өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг бүрэн хангаагүй байна.	124,977.3	Албан шаардлага өгөх
5	ГХБХБГ	Баянбулаг сумын дотуур байр, Галуут сумын төвийн шинэчлэл, Соого сейкео сургуулийн барилга зэрэг төсөл арга хэмжээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон зураг төсөвт тусгасан дутуу ажлуудад Барилгын үлдэгдэл ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй байна.	-	Албан шаардлага өгөх
6	ГХБХБГ	"РМБ" ХХК-ны гүйцэтгэсэн Усан бассейн, спортын цогцолборын барилганы ашиглалтын явцад агааржуулалтын систем ажиллахгүй болсон, дээвэр дээрх агааржуулалтын хамгаалалтын тоосгон хана нурснаас шалтгаалан агаар сэлгэлт байхгүй болсон байхад Барилгын тухай хуулийн 14.6 аймгийн Засаг дарга болон РМБ ХХК-ны хооронд байгуулсан 2019.06.03-ны өдрийн 2019/7/90 дугаар гэрээний 4.2.2 дахь заалтыг үндэслэн гүйцэтгэгч РМБ ХХК, захиалагчийн хяналт хийсэн байгууллагад мэдэгдэж, арга хэмжээ авч ажиллаагүй байна.	-	Албан шаардлага өгөх

1	2	3	4	5
7	БОНХОБТХ	Баянбулаг сумын дотуур байрны барилгын ажилд зураг төсөл зохиогчийн гэрээ байгуулсан "Баян дизайн" ХХК гэрээний 1.4-т заасны дагуу тус барилгын ажилд зохиогчийн хяналтыг зарагдсан шалтгаанаар тус барилгын ажилд зохиогчийн хяналт хийгдээгүй байхад аймгийн ЗДТГ-аас ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй ажлыг үргэлжлүүлж гүйцэтгэсэн нь цэвдэгтэй хөрстэй тус барилгыг цаашид ашиглах явцад гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.	14,168.4	Албан шаардлага өгөх
8	ГХБХБГ	Галуут сумын төсвийн шинэчлэлийг хүлээн авах комисс 2025.10.03-ны өдөр ажилласан байхад комиссын дүгнэлтийг 2025.08.19-ний өдөр гаргасан, төслийг хүлээн авах ажлын хэсгийн 4 гишүүний өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнаагүй байна.		Албан шаардлага өгөх
9	ГХБХБГ	"Энхбаялаг констракшн" ХХК-аас Заг сумын сургуулийн барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссыг 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр ажиллуулах тухай Б/92 албан бичгийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-д заасан баримт бичгийн бүрдлийг бүрэн шалгалгүйгээр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдөр ажилласан байхад барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр гаргасан байна. Тус дүгнэлтийг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 449.903.393 төгрөгийн санхүүжилтийг авсан байна.	-	Албан шаардлага өгөх
10	БОНХОБТХ	Заг сумын сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн хуудас, хурлын тэмдэглэл, "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 7.1 8 7.3 -т заасан комиссын гишүүдийн хэлэлцсэн асуудлыг хуралдааны тэмдэглэлээр баталгаажсан баримтыг аудитын явцад удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй.	-	Албан шаардлага өгөх
11	Аймгийн Засаг дарга	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5-т заасны дагуу аймгийн хэмжээнд мөрдөх барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах эрхийг аймгийн Засаг дарга хүлээхээр заасан байхад хэрэгжүүлээгүй байна.		Зөвлөмж өгөх
12	ГХБХБГ	2024-2025 онд ашиглалтад хүлээн авсан төсөл арга хэмжээний архивын баримтыг бүрдүүлээгүй байна.		Албан шаардлага өгөх
13	Аймгийн Засаг дарга	Баянбулаг сумын дотуур байрны гадна бохирын байгууламжийн ажил ажлын төсөвт байхгүй бөгөөд одоо түр хийсэн байгаа цооног барилгын суураас зай хэмжээ аваагүй ойрхон хийснээс болж ашиглаж эхлэх үед гарсан бүлээн ус хөрсөнд шингэж цэвдэгт нөлөө үзүүлж барилгын сууринд нөлөөлөх эрсдэлтээ тул барилга ашиглах боломжгүй байна.	-	Зөвлөмж өгөх

1	2	3	4	5
14	Аймгийн Засаг дарга	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд бий болсон 11,302.3 сая төгрөгийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглаж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг гаргаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	11,302,336.6	Албан шаардлага өгөх
Нийт			12,657,183.1	

_____оОо_____

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Аудитын менежер М.Алтантуяа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор Б.Должмаа

Аудитор Д.Даваадорж

Аудитор Д.Цэдэвцэвээн

2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр

Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Нутгийн удирдлагын ордон,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум 64090, Баянхонгор аймаг Монгол Улс

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ТОВЧИЛСОН ҮГИЙН МЭДЭЭЛЭЛ7

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....8-10

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ..... 10
БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМАГТ 2025 ОНД ШИНЭЭР ТӨЛӨВЛӨСӨН “АЙМГИЙН ТӨВИЙН ДУЛААНЫ СТАНЦЫН 2 ДУГААР ХЭЛХЭЭ, ДЭД БҮТЭЦ”-ИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА..... 11-12

БҮЛЭГ 2: БАЯНХОНГОР АЙМАГТ 2025 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭРХ ШИЛЖИН ХЭРЭГЖИХ ШИНЭ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ ТУЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДААГҮЙ БАЙНА.....12

БҮЛЭГ 3: БАЯНХОНГОР АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ АШИГЛАХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....12-23

ДҮГНЭЛТ: 24
ЗӨВЛӨМЖ:25

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....26

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
БОНХОБТХ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Хүснэгтийн жагсаалт

№	Агуулга	Хуудасны дугаар
1	Бодлогын бичиг баримтын уялдаа	11
2	Бүс, орон нутгийн хэмжээнд хэрэгжих дэд төсөл арга хэмжээний жагсаалт	12
3	Өмнөх онд хүлээн авсан төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт	13
4	Дутуу хийгдсэн төсөл арга хэмжээний талаар хяналт хэрэгжүүлсэн байгууллагаас ирүүлсэн тайлбар	13
5	Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт	21

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны аудитын сэдэв батлах тухай 2025 оны 25 дугаар тогтоол, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/01 тоот тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УАГ-ын ГАГ, Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ.

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оноос он дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болон аймгийн ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, сумдын Засаг даргын Тамгын газар, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал-ын дагуу аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, ярилцлага, судалгаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Авто замын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам.
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар тус тус баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга, хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд.
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм
- Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам
- Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм
- Барилгын ажлын захиалагчийн дүрэм
- Улс, орон нутгийн төсөл болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөл зохиох норм ба дүрэм стандарт
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд
- Батлагдсан зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ, бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлэн, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Д.Цэдэвцэвээн, Д.Даваадорж нар аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн мэргэжлийн шинжээч авч ажиллуулаагүй болно.

Аудитыг гүйцэтгэхэд учирсан хүндрэл, бэрхшээл

Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга 2026.01.26, аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ын дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн 2025.12.24, хөрөнгө оруулалтын мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч 2026.03.02-ны өдөр тус тус ажлаас чөлөөлөгдсөн нь УТХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээтэй холбоотой тодруулга авах, мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй байв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт:

- Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 185,349.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий, 61,559.9 сая төгрөгийн санхүүжилттэй 20 төсөл, арга хэмжээ,
- Тайлант онд шинээр 51,948.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий, 3,000.0 сая төгрөгийн санхүүжилттэй “Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн 2 дугаар хэлхээ, дэд бүтэц” төсөл, арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд аймгийн Засаг даргад шинээр эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ байхгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

Өмнөх оноос Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлж буй 65,663.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий, 20,086.6 сая төгрөгийн санхүүжилттэй 9 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 2025 онд нийт 20,086.6 сая төгрөг батлагдсанаас 1,632.0 сая төгрөгийн санхүүжилт дансанд төвлөрснөөс гүйцэтгэлээр 18,454.6 сая төгрөгийг олгосон байна.

Тайлант онд дээрх 9 төсөл арга хэмжээний 2 төсөл арга хэмжээ нь өмнөх онд хүлээн авсан үлдэгдэл санхүүжилт авсан ба 3 төсөл арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлт гарч, 3 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дуусаагүй үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа ба 1 төсөл арга хэмжээ нь 2025 онд баталсан төсвийг аваагүй зогссон байна.

Барьцаа хөрөнгийн данснаас өмнөх онд хэрэгжүүлсэн 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд нийт 2,045.4 сая төгрөгийг олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 7 төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2021 оны А/713 дугаар захирамжаар томилсон комисс хүлээн авсан байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМАГТ 2025 ОНД ШИНЭЭР ТӨЛӨВЛӨСӨН “АЙМГИЙН ТӨВИЙН ДУЛААНЫ СТАНЦЫН 2 ДУГААР ХЭЛХЭЭ, ДЭД БҮТЭЦ”-ИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинээр хэрэгжих 1, улсын хэмжээнд хэрэгжүүлэх 3 төсөл арга хэмжээ нь хөгжлийн бодлоготой уялдсан байна.

1.1. Баянхонгор аймгийн Засаг даргаас 2025 онд хэрэгжүүлэх нийт 370,686.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 53 төсөл, арга хэмжээг эрэмбэлэн үнэлж, /pimis.publicinvestment.gov.mn/ цахим системээр төлөвлөн саналыг аймгийн Засаг даргын 2024.06.27-ны өдрийн 1а/490 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

1.2. Хүргүүлсэн саналаас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 51,948.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 3,000.0 сая төгрөгөөр санхүүжих дүн бүхий “Аймгийн төвийн дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц” барих төсөл баталсан ба тус төсөл арга хэмжээг Баянхонгор аймагт эрх шилжүүлээгүй байна.

1.3. Аймгийн төвд баригдаж буй дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц барих төсөл, арга хэмжээг Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулж төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Бодлогын бичиг баримтын уялдаа

Бодлогын төрөл	Бодлогын бичиг баримт	Дугаар	Хамааралтай зүйл заалт
Дунд хугацааны	Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	8.1.8	Залуус хороолол болон Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
Дунд хугацааны	Баянхонгор аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	3.13.12	Аймгийн төвийн 2 дугаар хэлхээ, Залуус хороолол, Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
Урт хугацааны	“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	4.2.39	Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор дулааны эх үүсвэр, дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл хийнэ.
Богино хугацааны	Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд МУХТҮЧ 4.2.12	4.2.12	Инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжийг 10 хувиар нэмэгдүүлнэ.

Эх сурвалж: “БОНХОБТХ-ээс сангийн яаманд хүргүүлсэн албан бичиг, 2025 оны төсвийн тухай хууль”

1.4. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд улсын болон бүс, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр баталсан 3 багц арга хэмжээний хүрээнд Баянхонгор аймагт нийт 7,768.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2025 онд 1,924.8 сая төгрөгийн санхүүжилт олгох төсөл арга хэмжээг харьяа яамнаас хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 2. Бүс, орон нутгийн хэмжээнд хэрэгжих дэд төсөл арга хэмжээний жагсаалт

Аймаг нэр	Сум нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Дэд төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
Баянхонгор	Баянхонгор	Бэлчээрийн усан хангамж /Бүсүүд/	Инженерийн хийцтэй 3 худаг шинээр барьж байгуулах ажил	99.0	99.0
Баянхонгор	Өлзийт	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, /Бүсүүд/	Сумын төвийн инженерийн шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил	2,112.0	525.1
Баянхонгор	Баянцагаан, Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт, Шинэжинст сум/	Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, /Бүсүүд/	Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат	5,557.0	1300.7

Эх сурвалж: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль”

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна.

1.5. Баянхонгор аймагт баригдах “Аймгийн төвийн дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц”-ийн ажлыг төлөвлөхдөө зураг төсвийг магадлалаар баталгаажуулж техникийн тодорхойлолт, үнийн судалгаа, тооцоололд үндэслэсэн Сангийн сайдын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал -3”-ын дагуу төслийн шалгуур үзүүлэлтээр үнэлж төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 2. БАЯНХОНГОР АЙМАГТ 2025 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭРХ ШИЛЖИН ХЭРЭГЖИХ ШИНЭ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ ТУЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДААГҮЙ БАЙНА.

2.1. Баянхонгор аймагт 2025 онд шинээр хэрэгжиж буй “Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн 2 дугаар хэлхээ, дэд бүтэц” төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргад эрх шилжээгүй тул уг төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл бидэнд байхгүй байна.

БҮЛЭГ 3. БАЯНХОНГОР АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ АШИГЛАХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн барилга байгууламжийн ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад барилгын байнгын ашиглалтад авах комиссын дүгнэлтийг гаргаж, санхүүжилтийг олгосон байна.

3.1. Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 9 барилга байгууламжийн ажилд 2025 онд батлагдсан 20,086.6 сая төгрөгөөс 91.2 хувь буюу 18,454.6 сая төгрөгийн санхүүжилт төвлөрснийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд олгосон байна.

3.2. Тайлант онд дээрх 9 төсөл арга хэмжээний 2 төсөл арга хэмжээ нь өмнөх онд хүлээн авсан үлдэгдэл санхүүжилт авсан ба 3 төсөл арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын

дүгнэлт гарч, 3 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дуусаагүй үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа ба 1 төсөл арга хэмжээ нь 2025 онд баталсан төсвийг аваагүй зогссон байна.

Хүснэгт 3. Өмнөх онд хүлээн авсан төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт (сая.төг)

№	Төслийн код	Төсөл арга хэмжээний нэр	2025 онд олгохоор баталсан дүн
1	УТ2001900025002	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах Мах, ногооны 1000тн-ийн зоорийн барилга, Бойны газрын барилга (Багц-3)	819.0
2	УТ2001900025006001	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах Ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил (Багц-1)	1,005.6
3	УТ2003100009	Усан бассейн спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	1,047.1
		ДҮН	2,871.7

Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралт, дансны хуулга

3.3. Харин Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын УТ2102900137 төслийн кодтой Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/ ажилд 2025 онд олгохоор баталсан 653.8 сая төгрөгийн санхүүжилт гүйцэтгэгч аж ахуйн нэгж ажил хийж, гүйцэтгэл гаргаагүй тул санхүүжилтийн эрх нээгдээгүй, 2025 онд баталсан санхүүжилтийг авах боломжийг алдсан байна. Тус төсөл арга хэмжээ нь анх төсөв батлагдах үед магадлал хийгдээгүй, төсөвт өртөг Төсвийн тухай хууль нэмэгдсэн дүнгээр батлаагүйгээс шалтгаалан ажил зогссон байна.

3.4. Мөн өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 6,961.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй Баянхонгор сумд гүйцэтгэсэн аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын үлдэгдэл санхүүжилтийн 833,7 сая төгрөг 2025, 2026 онд төсөв батлагдаагүй байна.

3.5. Дээрх дутуу хийж орхигдуулсан 2 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байсан аймгийн ГХБХБГ-аас тодруулахад дараах мэдээллийг өгсөн болно.

Хүснэгт 4. Дутуу хийгдсэн төсөл арга хэмжээний талаар хяналт хэрэгжүүлсэн байгууллагаас ирүүлсэн тайлбар

№	Төсөл арга хэмжээний нэр	Ирүүлсэн тайлбар
1	Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/	Баацагаан сумд 2022-2025 оны хооронд сумын төвийн шинэчлэл ажлын хүрээнд 6х9.5 харьцаатай цэвэрлэх байгууламжийн удирдлагын байр болон 60м3-ын хүчин чадалтай 4.5х24 харьцаатай цэвэрлэх байгууламжийн суурийн цутгалтын ажил хийгдсэн. Гадна дулааны ажил ДХ1-ээс ДХ14 хүртэл 1000м урт шугам, гадна ариутгах татуургын ажил БХ1-БХ84 хүртэл 2345м урт шугам, гадна цахилгааны ажил 240кВт-ын 1 ГТП, 8 тулгуур шонгийн 435м урт цахилгааны шугам хийгдсэн. Хяналтын явцад дулааны худаг 5-аас дулааны худаг 9 хүртэлх бетон сувгийн бетон цутгалтыг буулган дахин цутгуулсан, цэвэрлэх байгууламж, усан сангийн барилгын үндсэн хийцэл хийгдсэн боловч гадна, дотор засал, тоноглолын ажлууд төсөв байхгүй гэсэн шалтгаанаар зогссон байна. Нийт ажлын гүйцэтгэл 85 хувь.
2	Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ	Гүйцэтгэгч нь Шинэ суурьшлын бүсийн гадна дулааны шугам: ф273 мм, ф219 мм, ф159 мм, ф133 мм, ф108 мм, ф89 мм-ийн голчтой, 10503.0 м урттай, гадна ус хангамжийн шугам: ф160 мм-ийн голчтой, 2 хос шугам, 10809.0 урттай, ариутгах татуургын шугам: ф110 мм, ф300 мм-ийн голчтой, 14116.0 м урттай гүйцэтгэсэн. Гэрээний хугацаа 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр дууссан, гүйцэтгэгч хийгдсэн ажлуудыг хүлээлгэж өгөөгүй. Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст гэрээ дүгнэх талаар албан бичгийг хүргүүлсэн.

Эх сурвалж. Аймгийн ГХБХБГ-ын ахлах мэргэжилтний тайлбар

3.6. Баянхонгор аймагт эрх шилжээгүй дараах ажлуудад 2025 онд төсөв батлагдаагүйгээс ажил хийгдээгүй байна. Үүнд:

- Баянхонгор сумын 8 дугаар баг Шаргалжуут тосгонд баригдаж байгаа 240 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил 2020 онд эхэлж, барилгын үндсэн хийцлэл, гадна, дотор ханын өрлөг, цонх, хаалга суулгах ажлууд хийгдсэн, 2024 оноос барилга угсралтын ажил төсөв хүрэхгүй шалтгаанаар зогссон, барилгын гүйцэтгэл 75 хувьтай байна. Барилгын зураг төсвийг 2025 онд дахин магадлалаар орж төсөв, 2026 оны Төсвийн тухай хуульд 2,096.1 сая төгрөгийг олгохоор баталсан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байна.
- Баянхонгор аймгийн Богд сумын сургуулийн дотуур байр 2020 онд эхэлж, барилгын үндсэн хийцлэл, цутгалт 90 хувьтай, гадна, дотор талын өрлөг, шаврын ажлууд 80 хувьтай, барилгын нийт гүйцэтгэл 65 хувьтай байна. Барилгын зураг төсвийг 2025 онд дахин магадлалаар орж төсөв, 2026 оны Төсвийн тухай хуульд 3,312.7 сая төгрөгийг олгохоор баталсан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад эхлүүлсэн боловч хэрэгжиж дуусаагүй зогссон дээрх 2 төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг аймгийн ГХБХБГ-аас холбогдох газруудад хүргүүлсэн байна.

3.7. Өмнөх оны аудитаар гэрээний хэрэгжих хугацаа дуусаагүй байсан, 2024 онд ажлыг бүрэн гүйцэтгээгүйгээс оны эцэст барьцаа хөрөнгийн дансанд санхүүжилтийг байршуулсан 3 төсөл арга хэмжээний санхүүжилтэд тайлант онд 2,045.4 сая төгрөгийн гүйцэтгэлийг олгосон байна.

3.8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж, эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн Баянхонгор сумын 640 хүүхдийн суудалтай Соогоо сейкео сургууль, Нийгмийн даатгалын хэлтсийн барилгыг гэрээнд заасан хугацаанаас өмнө хүлээлгэн өгч, ашиглалтад оруулсан байна.

3.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг холбогдох баримт, материалыг үндэслэн олгохдоо Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-т заасан баримт материалыг бүрдүүлээгүй байхад барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлтийг урьдчилан гаргаж, санхүүжилтийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹, 13.5², 13.6³, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Заг сумын сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комисс ажиллаагүй атлаа дүгнэлтийг урьдчилан гаргаж, гүйцэтгэлийн санхүүжилтэд 449.9 сая төгрөгийг олгосон;
- Галуут сумын төвийн шинэчлэлийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт бүрэн хангаагүй байхад урьдчилан гаргаж, гүйцэтгэгчид 523.9 сая төгрөгийг олгосон байна.

Шийдвэрлэлт: Дээрх төсөл арга хэмжээг ашиглалтад оруулах комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, Баянхонгор аймгийн Засаг даргын 2026.01.08-ны өдрийн А/14

¹ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

² Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.

³ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

⁴ Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно.

дүгээр захирамжийн дагуу ашиглалтад оруулах комиссыг ажиллуулж, зөрчлийг арилгаж, хүлээн авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.10. Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3⁵, 14.4⁶, 14.5⁷ зөрчиж, чанарын баталгааг олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- Заг сумын сургуулийн барилгыг ашиглалтад оруулаагүй байхад барилгын зураг төсөв зөрүүтэй байсан шалтгаалан төсөвт зардал хүрэхгүй байгаа гэсэн гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс тавьсан хүсэлтийг үндэслэн барилгыг ашиглаж эхлээгүй байхад аймгийн Засаг даргын 2026.02.09-ний өдрийн А/89 дүгээр захирамжаар 224.7 сая төгрөгийн чанарын баталгааг чөлөөлж, гүйцэтгэгч аж ахуйн нэгжид олгосон байна.

Шийдвэрлэлт: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

- Баянбулаг сумын дотуур байрны барилгын ажлын дулааны шугамын ажлыг зураг төсөвт байсан хэмжээнээс бага зайд гүйцэтгэж, хэмнэгдсэн төсвөөр зураг төсөвт тусгаагүй ажлыг хийсэн гэх боловч хурлын тэмдэглэлээр баталгаажуулаагүй, хийсэн ажлын тайланг тоо хэмжээ, мөнгөн дүнгөөр баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэлт: Дулааны шугамын төсвийн хэмнэлтээр хийсэн ажлын тайланг тоо хэмжээ, мөнгөн дүнгээр баталгаажуулж, хувийн хэрэгт хийх албан шаардлагыг аймгийн БОНХОБТХ-т өгөв.

Баянбулаг сумын сургуулийн дотуур байрны зураг төсвийн зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байхад захиалагч буюу аймгийн ЗДТГ-аас холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

3.11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн ГХБХБГ-аас хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч ГХБХБГ-ын дарга, “Барилгын хөгжлийн төв”-ийн захирал нарын хооронд “Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилга байгууламжийн ажилд захиалагчийн техник хяналтыг гүйцэтгүүлэх гэрээ”-г 2025.01.31-ний өдөр байгуулж, шилжих 7, төсөвгүй 2, шинэ 1 төсөл арга хэмжээг зураг төсөл, норм дүрмийн дагуу чанартай гүйцэтгүүлэх, санхүүжилтийн гүйцэтгэлийг ГХБХБГ-аар хянуулж баталгаажуулж, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнасан байна.

3.12. Баянхонгор аймгийн ГХБХБГ нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулаагүй, харин 2026.02.26-ны өдөр улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэх гэрээг аймгийн ГХБХБГ аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-тай байгуулж,

⁵ Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

⁶ Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ.

⁷ Энэ хуулийн 14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно.

аймгийн Засаг даргаар батлуулж, гэрээний 2.3⁸-т төсөвт өртөгт тусгасан хяналтын зардлын 60 хүртэл хувийг аймгийн ГХБХБГ-т олгохоор тусгажээ.

3.13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтын зардалд 2025 онд 288.5 сая төгрөг дансанд төвлөрснөөс аймгийн ГХБХБГ-т 47.7 хувь буюу 137.5 сая төгрөгийг олгосон байна.

3.14. Техник хяналтын данснаас аймгийн Засаг даргын 2025 оны А/169 дүгээр захирамжаар аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн дарга, мэргэжилтнүүд, “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн албан хаагчдыг БНХАУ-ын Гуанжоу хотод болох Кантон файр олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцож туршлага судлахад 16.5 сая, БНХАУ-ын Жючуаний мужийн МТИС үйл ажиллагаа, туршлага судлах зардалд 4.7 сая нийт 21.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тус асуудалд аймгийн Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланд албан шаардлага хүргүүлсэн болно.

3.15. Техник хяналтын дансанд төвлөрсөн орлогоос дээрх байдлаар зориулалт бусаар зарцуулж байгаа нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5⁹-т тусгасан зардал болон аймгийн ГХБХБГ-аас бусад байгууллагуудын мэргэжилтэн, байцаагчид томилолтоор ажиллахад төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар явахгүй тохиолдол гардаг, үүнээс болж эрүүл мэнд, цахилгаан гэх мэт нарийн мэргэжлийн мэдлэг шаардсан зарим ажил дутуу хянагдах эрсдэл үүсэхээр байгаа тул цаашид улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх томилолтын зардлыг захиалагчийн хяналтын зардлаас шийдвэрлэж байхыг аймгийн Засаг даргад зөвлөв.

3.16. Баянбулаг сумын дотуур байрны барилгын ажилд зураг төсөл зохиогч, аймгийн ЗДТГ-ын дарга нарын 2020 онд байгуулсан гэрээний хэрэгжилт, үүрэгтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Гүйцэтгэгч нь 2020 онд 3 удаа, 2022 онд 1, 2023 онд 1 удаа хийснээс өөр хяналт хийсэн тайлан байхгүй, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлт гаргахад 2025.12.19-ний өдөр зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг зөвхөн нэг хүний гарын үсгээр албажуулан гаргаж Барилга, хот байгуулалтын сайдын 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4.2.1, 5.8 -т заасан үүргээ биелүүлээгүй байна.
- Гүйцэтгэгч нь гэрээний 1.4 -т заасны дагуу тус барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй, гэрээний үүргээ зөрчсөн байхад аймгийн ЗДТГ-аас ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүйгээс барилгын ажлын зураг төсөв зохиогчийн хяналт дутуу хийгдсэн нь Барилгын тухай хуулийн 13.4, 37.4, 38.1.4 заалтуудыг зөрчсөн байна.
- Гэрээнд зохиогчийн хяналт хэрэгжүүлэх үүрэг, ажлын явцын талаар тодорхой тусгаагүй, захиалагчаас тус аж ахуйн нэгжид гэрээний үүргийг биелүүлэх талаар шаардлага тавиагүйгээс зохиогчийн хяналтыг 2024-2025 онд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

⁸ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламжийн ажлын төсөвт өртөгт тусгагдсан хяналтын зардлаас энэхүү гэрээг дүгнэж 60 хүртэл хувийг ГХБХБГ-т захиалагчийн техник хяналт гүйцэтгэсэн үйл ажиллагаанд зарцуулахаар олгоно.

⁹ Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

Баянбулаг сум нь цэвдэгтэй хөрстэй бүсэд хамаардаг онцлогтой байхад зураг төсөл зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, мөн уг зөрчилд захиалагчийн зүгээс зохих арга хэмжээ авч ажиллаагүй нь барилга байгууламжийг цаашид ашиглах явцад бүтээцийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх, улмаар ашиглалтын эрсдэл нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Шийдвэрлэлт: Цаашид гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөв зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2¹⁰-т заасны дагуу зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх талаар тодорхой тусгах, зохиогчийн хяналтыг гэрээний дагуу гүйцэтгэж, тайлагнаж байгаад хяналт тавьж ажиллах, тус ажилд хөндлөнгийн шинжээчийг ажиллуулж, дүгнэлтийг гаргах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-т хүргүүлэв.

3.17. Заг сумын сургуулийн барилга, Баянбулаг сумын сургуулийн дотуур байрны зохиогч гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй, зураг, төсвийг зөрүүтэй гаргасан нь Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.3¹¹ дахь заалтыг зөрчсөн байна. Иймд Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 12.1.6.3¹² заалтыг зөрчсөн эсэхэд арга хэмжээ авч ажиллахыг аймгийн ГХБХБГ-т зөвлөв.

3.18. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж, ашиглалтад орсон зарим барилгыг ашиглах боломжгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянбулаг сумын дотуур байрны гадна бохирын байгууламжийн ажил ажлын төсөвт байхгүй бөгөөд одоо түр хийсэн байгаа цооног барилгын суураас зай хэмжээ аваагүй ойрхон хийснээс шалтгаалж хэрэглээнд ашиглаж эхлэх үед гарсан бүлээн ус хөрсөнд шингэж цэвдэгт нөлөө үзүүлж барилгын сууринд нөлөөлөх эрсдэлтэй тул барилга ашиглах боломжгүй байна.

Шийдвэрлэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан боловч зураг төсөвт гадна шугам сүлжээ, эх үүсвэрийг иж бүрэн төлөвлөөгүйгээс зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүгийн болон бусад эх үүсвэрийг шийдвэрлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.19. Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн бетон дүүргэгч материалын лабораториос бетон шооны хангаагүй дээжийн мониторингоор Баянхонгор аймагт баригдаж буй барилга байгууламжийн бетон шооны сорьц хангаагүй асуудалд аймгийн ГХБХБГ-аас тайлбар авч, нотлох баримтыг ажлын баримтад авч ажиллав.

¹⁰ Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан дараах 3 хэлбэрээр гүйцэтгэнэ.

3.2.1. барилгын ажилд байнгын хяналт тавих;

3.2.2. тогтмол хуваарийн дагуу барилгын ажилд хяналт тавих

3.2.3. барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

¹¹ Зураг төсөл зохиогч дараах чиг үүрэгтэй: зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх;

¹² Зураг төсөл зохиогч хуульд заасан: чиг үүргээ хэрэгжүүлээгүй;

3.20. Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1¹³, 35.1.6¹⁴, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.2¹⁵ заалтыг үндэслэн Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.11.24-ний өдрийн А/713 дугаар захирамжийн дагуу комиссын бүрэлдэхүүн 2025 онд нийт 7 төсөл арга хэмжээг хүлээн авах дүгнэлт гаргасан байна.

3.21. Барилгын тухай хуулийн 11, 14, 48 дугаар зүйл, “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу төсөл арга хэмжээний бүрдүүлсэн баримтыг тулган шалгахад барилга байгууламжийн байнгын ашиглалтад оруулах комисс Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-т заасан баримтын бүрдлийн хангаагүй байхад комиссын дүгнэлт гаргасан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлт хангалтгүйгээс дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс Заг сумын сургуулийн барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах тухай хүсэлтийг 2026.01.15-ны өдөр Б/92 албан бичгийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2026.02.04-ний өдөр ажилласан байхад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг 2025.11.18-ны өдөр урьдчилан гаргасан;
- Заг сумын сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудас, хурлын тэмдэглэл, “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 7.1¹⁶ 7.3¹⁷-т заасан комиссын гишүүдийн хэлэлцсэн асуудлыг хуралдааны тэмдэглэлээр баталгаажсан баримтыг аудитын явцад удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй;
- Галуут сумын төвийн шинэчлэлийг хүлээн авсан ажлын хэсэгт “Эрчим хүч” ЦТХХК-ийн ТБТТТ-ийн ахлах инженер ажилласан байхад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг ерөнхий инженер бичиж, гарын үсэг зурсан;
- Галуут сумын төвийн шинэчлэлийг хүлээн авах комисс 2025.10.03-ны өдөр ажилласан байхад комиссын дүгнэлтийг 2025.08.19-ний өдөр гаргасан, төслийг хүлээн авах ажлын хэсгийн 4 гишүүний өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнаагүй байна.
- Баянбулаг сумын дотуур байрны барилгыг хүлээн авах комиссын нарийн бичгийн даргаар гүйцэтгэгчийн инженер ажилласан нь Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны А/713 дугаар захирамжийг зөрчсөн байна.

Дээрх зөрчил нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.16¹⁸, 48 дугаар зүйлийн 48.5¹⁹, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 2.1, 5.1, 7.1, 7.3, 7.6, 8.1, 8.6, 8.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

¹³ Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих

¹⁴ Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах;

¹⁵ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг харьяаллын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэлдэхүүнтэй томилно:

¹⁶ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс (цаашид “Комисс” гэх) нь барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

¹⁷ Комиссын нарийн бичгийн дарга комиссын хуралдааны бэлтгэлийг хангах, гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хуралдаан зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, дүгнэлт үйлдэх ажлыг хариуцах бөгөөд Барилгын тухай хуулийн 48.5-д заасан баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан бол комисс ажиллуулах мэдээдлийг комиссын гишүүдэд тараана.

¹⁸ Барилгын ажлын захиалагч дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: барилга байгууламжийн баримт бичгийн үнэн зөвийг хариуцах;

¹⁹ Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар хүсэлт гаргах бөгөөд түүнд дараахь баримт бичгийг хавсаргана:

Шийдвэрлэлт: Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь заалтад заасан баримтуудыг бүрдсэний дараа барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссыг ажиллуулж, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, аймгийн Засаг даргын 2026.01.08-ны өдрийн А/14 дүгээр захирамжийг мөрдөж ажиллах, хяналтыг сайжруулах албан шаардлагыг аймгийн Засаг дарга, аймгийн ГХБХБГ-ын дарга нарт хүргүүлэв.

3.22. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллаагүй зөрчил аудитаар илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- *"Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ажилчдын байр, халуун усны барилгын ажил гүйцэтгэгч нь барилгын гадна тохижилтын ажил 70 хувийн гүйцэтгэж бүрэн дуусаагүй, барилгын гаднах хаяавчны цутгалт бүрэн хийгдээгүй, цутгасан бетон хөлдөж хагарсан байдалтай, комиссын гишүүдээс өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг бүрэн хангаагүй;*
- *Баянбулаг сумын дотуур байр, Галуут сумын төвийн шинэчлэл, Соого сейкео сургуулийн барилга зэрэг төсөл арга хэмжээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон зураг төсөвт тусгасан дутуу ажлуудад Барилгын үлдэгдэл ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй;*
- *Усан бассейн, спортын цогцолборын барилгын ашиглалтын явцад агааржуулалтын систем ажиллахгүй болсон, дээвэр дээрх агааржуулалтын хамгаалалтын тоосгон хана нурснаас шалтгаалан агаар сэлгэлт байхгүй болсон байна. Барилгын тухай хуулийн 14.6, "Аймгийн Засаг дарга болон гүйцэтгэгч хооронд байгуулсан 2019.06.03-ны өдрийн 2019/7/90 дугаар гэрээний 4.2.2 дахь заалтыг үндэслэн ашиглагч байгууллагын зүгээс гүйцэтгэгч, захиалагчийн хяналт хийсэн байгууллагад мэдэгдэж, арга хэмжээ авч ажиллаагүй байна.*

Шийдвэрлэлт: Гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй Барилгын үлдэгдэл ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, дутуу ажлуудыг холбогдох стандарт, норм дүрэм, ашиглалтын шаардлагад нийцүүлэн хийлгүүлж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж хүлээн авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

3.23. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын даргаар ажилласан аймгийн ГХБХБГ-ын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга, комиссын нарийн бичгийн даргаар ажилласан аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ын дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн нар нь ажлаас чөлөөлөгдсөн байна.

Баянхонгор сумын Соого сейкео сургуулийн барилгыг барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс 2 удаа ажилласан боловч Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5.3-т заасан "зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт" гараагүйгээс барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлт гараагүй байсан бөгөөд аудитын явцад 2026.04.22-ны өдөр ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан байна.

3.24. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхийг аудитаар шалгахад хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний ерөнхий мэдээллийг иргэдэд таниулах зорилготой байршуулсан мэдээлэл бүхий зурган самбарыг зарим барилга байгууламжийн ажилд байршуулаагүй, байршуулсан самбарууд урагдаж хуучирсан,

алга болсон нь Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4²⁰, 37 дугаар зүйлийн 37.1.2²¹ болон Монгол Улсын стандарт MNS 7023:2023-т заасныг зөрчсөн байгаа тул цаашид Монгол Улсын стандарт MNS 7023:2023-т заасан шаардлагыг дагуу мэдээллийн самбарыг дахин бэлтгэж байршуулахыг аймгийн ГХБХБГ-т зөвлөв.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн хэмжээнд мөрдөх “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ыг батлаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5-т заасан журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

Хөдөө аж ахуйн кластер төслөөр бий болсон 11,302.4 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй байна.

3.25. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, 2025 онд хүлээн авсан 15,503.7 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах шийдвэр эрх бүхий байгууллагаас гараагүйгээс хүлээгдэж байна. Үүнд:

- Галуут сумын төвийн шинэчлэл төслийн арга хэмжээний хүрээнд бий болсон 9,960.8 сая төгрөгийн барилга байгууламж, зам; инженерийн байгууламжууд;
- Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд хийгдсэн 673.7 сая төгрөгийн өртөг бүхий 1 ширхэг өвлийн хүлэмж;
- Хөдөө аж ахуйн кластерийн үйлдвэрлэл төслийн хүрээнд бий болсон 4,869.2 сая төгрөгийн мах ногооны зоорь

Иймд улсын төсвийн хөрөнгөөр бий болсон, хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр эзэмшигч тогтоох шийдвэр гаргуулж, нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн эсэхийг 2026 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар үзэхээр шийдвэрлэв.

3.26. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээг зорилтот түвшинд хүрсэн эсэх, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж, ашиглалтын байдалд мэргэжлийн байгууллагуудын оролцоотой дүн шинжилгээ хийж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4²²-т заасантай нийцэхгүй байгаа тул цаашид үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

3.27. Барилгын тухай хуулийг хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан барилга байгууламжийн баримт бичгийг төрийн архивд шилжүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитын хамрах хүрээнд ашиглалтад хүлээн авсан 4 барилгын баримт бичгийг гүйцэтгэгчээс аймгийн ГХБХБГ-ын архив болон төрийн архивд шилжүүлээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 , Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө

²⁰ Барилга байгууламжийн зураг төсөл, байр зүйн дэвсгэр зураг зэрэг мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байна.

²¹ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10, 8.6.11-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаарх иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах;

²² хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;

оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.3.7, 5.4.10 заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Барилгын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2²³, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 6.1.5²⁴ заалтыг үндэслэн гүйцэтгэгч аж ахуйн нэгж, холбогдох буруутай албан тушаалтнуудаар архивын баримтыг бүрдүүлэх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

3.28. Өмнөх оны аудитаар нийт 40,898.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 41.4 сая төгрөгийн дүнтэй 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 40,454.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 5 албан шаардлага, мөн 401.9 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргуулахгүй байх чиглэлээр 8 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлснээс төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 5 .Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

Шийдвэрийн нэр	Шийдвэрийн агуулга	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Шийдвэрийн хэрэгжилт
Зөвлөмж	Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон томоохон бүтээн байгуулалт, жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг холбогдох мэргэжлийн агентлаг, хэлтсүүдийг оролцуулсан ажлыг зохион байгуулж тодорхой шийдлийг гарган хэрэгжүүлэх.	Аймгийн засаг дарга	ЗДТГ-ын 2025.12.16-ны өдрийн 1а/1111 дугаар албан бичиг
	Тендерийн баримт бичгийн техник болон хууль эрх зүйн шаардлагыг салбарын холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж байх, шалгуур үзүүлэлтийг харьцуулах боломжтой тодорхой, ойлгомжтой оруулж байх.		
	Гэрээний үүргээ хугацаандаа бүрэн биелүүлдэггүй, удаа дараа чанаргүй ажил хийсэн гүйцэтгэгчийг Сангийн яамны хар жагсаалтад оруулах хүсэлтийг уламжлах.		Хугацаа болоогүй
	Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 2.9 -д заасны дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдээр хяналтыг гүйцэтгүүлэх асуудлыг судалж, захиалагчийн хяналтыг сайжруулах.		
	Тендерийн баримт бичигт туссан ерөнхий шаардлагыг үнэлэх талаар үнэлгээний хорооны гишүүдэд арга, зүйн зөвлөгөө өгч ажиллах.	Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга	ХХАГ-ын 2025.12.01-ний өдрийн 1/230 албан бичиг
	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан зах зээлийн үнийн судалгаа хийх үүргээ хэрэгжүүлж ажиллах		
Албан шаардлага	Төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийг техникийн тодорхойлолтын дагуу иж бүрэн хүлээн авч байх Шинэ хөдөө, Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж төслийн хүрээнд Баянхонгор аймагт Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих.	Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга	ОНӨГ-ын 2025.12.02-ний өдрийн 322 дугаар албан бичиг хавсралтууд
	Боловсролын тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу Баян-Бүрдийн багийн цэцэрлэгт хүлээлгэж өгөх.	Боловсролын газар	Боловсролын газрын 2025.12.02-өдрийн 538 дугаар албан бичиг, зураг
	Хөрөнгийн эзэмшигчийг тогтоолгох, нягтлан бодох бүртгэлд тусгах	Аймгийн Орон нутгийн өмчийн газар	Аймгийн засаг даргын 2025.12.22-ны өдрийн 1а/1139

²³ Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

²⁴ Энэ журмын 5.4.10-д зааснаар баримт бичгийг архивд өгөөгүй тохиолдолд холбогдох хариуцлагыг тухайн асуудал хариуцсан албан тушаалтан хүлээнэ;

	Баянбулаг сумын дотуур байрны барилгын ажлын хана, дулаалгын ажлыг Улсын байцаагчаар хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулж, дахин гүйцэтгүүлэх	ГХБХБГ	ГХБХБГ-ын 2025.11.28-ний өдрийн 773 дугаар албан бичиг хавсралтууд
	Төсөвт тусгагдсаны дагуу автозамыг гүйцэтгэгчээр буцаан нөхөн сэргээх	Б-Софт ХХК	ЗДТГ-ын 2025.12.05-ны өдрийн 5/1417 дугаар албан бичиг, нөхөөс хийсэн ажлын тайлан.
	Хүрээмарал сумын ЭМТ-ийн барилгыг Улсын байцаагчаар хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулах	ГХБХБГ	ГХБХБГ-ын 2025.11.28-ний өдрийн 773 дугаар албан бичиг хавсралтууд
Төлбөрийн акт	Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд дутуу нийлүүлсэн 17359.6 мянган төгрөгийн төгрөгийг төсөвт төлүүлэх.	Тэнгэрийн уул ХХК	2025.09.03-нд Журналын № 36628643
	Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд зах зээлийн үнээс хэт өндөр үнээр нийлүүлсэн тоног төхөөрөмжийн үнийн зөрүүг төлүүлэх	Тэнгэрийн уул ХХК	2025.05.21-нд Журналын № 33683984

Эх сурвалж: Шийдвэрийн биелэлт ирүүлсэн албан бичгүүд

3.29. Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.9 -д заасны дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдээр хяналтыг гүйцэтгүүлэх асуудлыг судалж, захиалагчийн хяналтыг сайжруулах талаар өмнөх оны аудитаар аймгийн Засаг даргад зөвлөмж өгч, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй ба аудитын явцад зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээллийг аймгийн ЗДТГ-аас албан бичгээр авахад “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллахаар судалж байна” гэсэн хариу ирүүлсэн болно. Иймд цаашид аудитаар өгсөн дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүн гаргаж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

3.30. Мөн өмнөх оны аудитаар аймгийн Засаг даргад “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон томоохон бүтээн байгуулалт, жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг холбогдох мэргэжлийн агентлаг, хэлтсүүдийг оролцуулсан ажлыг зохион байгуулж тодорхой шийдлийг гарган хэрэгжүүлэх” зөвлөмжийг өгч, аймгийн ИТХ-д тус асуудлыг толилуулсан байна.

3.31. Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025.03.11-ны өдрийн 05/07 дугаар хурлын хуралдааны тогтоолоор Ингэний сүүний үйлдвэр, 2 ширхэг өвлийн хүлэмжийг ТӨБЗГ-тай зөвшилцсөн саналыг ирсний дараа уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахыг дэмжиж аймгийн засаг даргад даалгасан байна.

3.32. Баянхонгор аймгийн Засаг даргын 2025.07.25-ны өдрийн А/430 дугаар захирамжаар “Ингэний сүүний үйлдвэрийг хувьчлах сонгон шалгаруулалтын журам” баталж, тус журмын хүрээнд 2025 онд уралдаант шалгаруулалтын аргаар 3 удаа сонгон шалгаруулалтыг зарласан боловч шаардлага хангасан оролцогч оролцоогүй байна.

3.33. Харин аймгийн Засаг даргад даалгасны дагуу өвлийн хүлэмжийг хувьчлах журмыг боловсруулаагүй, уралдаант шалгаруулалт зарлаагүй байна.

3.34. Аудитын явцад аймгийн ОНӨГ-аас өмнөх жилүүдэд ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгааг авахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хүлээн авсан Хөдөө аж ахуйн кластер төслөөр бий болсон нягтлан бодох бүртгэлд тусгасан 5,759.5 сая төгрөгийн ингэний сүүний үйлдвэр, барилга тоног төхөөрөмж, өвлийн 2 ширхэг хүлэмж, бүртгэлд тусгаагүй 5,542.9 сая төгрөгийн мах ногооны зоорь, өвлийн 1 ширхэг хүлэмж зэрэг хөрөнгийг ашиглаагүй байна.

3.35. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, бүрэн хэрэгжүүлснээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн эсэхийг мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан дүгнэж ажиллаагүй байгаа тул цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Шийдвэрлэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд бий болсон барилга, тоног төхөөрөмжийг ашиглаж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитаар нийт 12,657.2 сая төгрөгийн 14 зөрчил илрүүлж, 12,657.2 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 12 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар 2 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

---oOo---

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Баянхонгор аймагт 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Аймгийн төвийн дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц”-ийн төсөл, арга хэмжээг холбогдох хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.
2. Баянхонгор аймагт 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжих шинэ төсөл, арга хэмжээ байхгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.
3. Барилга байгууламжийн байнгын ашиглалтад оруулах комисс нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг зөрчиж, комиссын дүгнэлтийг гарган, гүйцэтгэлийн санхүүжилтийг олгосон байна.
4. Заг сумын сургуулийн барилгыг ашиглалтад оруулаагүй байхад барилгын зураг төсөв зөрүүтэй байсан шалтгаалан төсөвт зардал хүрэхгүй байгаа гэсэн гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс тавьсан хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2026.02.09-ний өдрийн А/89 дүгээр захирамжаар 224.7 сая төгрөгийн чанарын баталгааг олгосон байна.
5. Баянбулаг сумын сургуулийн дотуур байрны ажилд зураг төсвийн зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс цэвдэгтэй газарт баригдсан тус барилгыг цаашид ашиглах явцад гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.
6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн Баянбулаг сумын сургуулийн дотуур байрны барилгын гадна бохирын байгууламжийн ажлыг зураг төсөвт тусгаагүйгээс гүйцэтгээгүй бөгөөд уг барилгыг зориулалтын дагуу ашиглах боломжгүй байдал үүссэн байна.
7. Барилгын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиглалтад оруулсан барилга байгууламжийн баримт бичгийг төрийн архивд шилжүүлээгүй байна.
8. Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд бий болсон 11,302.3 сая төгрөгийн өртөг бүхий ингэний сүүний үйлдвэр, өвлийн 3 ширхэг хүлэмж, мах ногооны зоорь зэрэг хөрөнгийг бүрэн ашиглаагүй байна.
9. Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг мөрдөөгүйгээс Баянхонгор аймгийн хэмжээнд мөрдөх “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ыг батлаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Э.ЭНХБАТ ТАНАА

1. Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журмыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулж батлан, хэрэгжилтийг хангуулж ажиллах
2. Баянбулаг сумын сургуулийн дотуур байрны гадна бохирын байгууламжийн ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээг авч, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх